



# МОНГОЛБАНКНЫ ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ТУШААЛ

2010 оны 11 сарын 22 өдөр

Дугаар 674

Улаанбаатар хот

“Дотоодын банкнаас Монголбанкинд гадаад валютын хадгаламж байршуулах журам”,  
“Дотоодын банкнаас Монголбанкинд гадаад валютын хадгаламж байршуулах заавар”-ыг батлах тухай

Төв банк (Монголбанк)-ны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 1 дүгээр хэсгийн 2 дахь заалт, Валютын зохицуулалтын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 1 дэх заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1.“Дотоодын банкнаас Монголбанкинд гадаад валютын хадгаламж байршуулах журам”-ыг нэгдүгээр хавсралтаар баталсугай.

2.“Дотоодын банкнаас Монголбанкинд гадаад валютын хадгаламж байршуулах заавар”-ыг хоёрдугаар хавсралтаар баталсугай.

3.Энэ тушаалын хавсралтаар батлагдсан журам, зааврыг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг Валот, эдийн засгийн газар (Г.Дэлгэрмаа), Төлбөр тооцоо, бүртгэлийн газар (М.Амгалан)-т тус тус үүрэг болгосугай.

4.Энэ тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Дотоод аудитын газар (Г.Тогтохбаатар)-т даалгасугай.

ЕРӨНХИЙЛӨГЧ



И.ПҮРЭВДОРЖ

## **ДОТООДЫН БАНКНААС МОНГОЛБАНКАНД ГАДААД ВАЛЮТЫН ХАДГАЛАМЖ БАЙРШУУЛАХ ЖУРАМ**

### **НЭГ. Нийтлэг үндэслэл**

- 1.1 Энэ журмын зорилго нь дотоодын банкуудаас (цаашид банк гэх) Монголбанканд гадаад валютын хадгаламж байршуулах үйл ажиллагааг зохицуулах, талуудын эрх, үүрэг, хариуцлагыг тодорхойлоход оршино.
- 1.2 Гадаад валютын хадгаламж байршуулах хэлцэл (цаашид хадгаламжийн хэлцэл гэх)-ийг Монголбанк нь зөвхөн банкны үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй, Монгол Улсын нутаг дэвсгэр дээр үйл ажиллагаа явуулж буй банктай хийнэ.
- 1.3 Гадаад валютын хадгаламж байршуулах нөхцлийг Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаалаар батална.
- 1.4 Гадаад валютын хадгаламж байршуулах хэлцлийг Монголбанкийг төлөөлж Мөнгөний захын үйл ажиллагаа хариуцсан газар хийнэ.

### **ХОЁР. Нэр томъёоны тодорхойлолт**

- 2.1 Энэ журамд хэрэглэсэн нэр томъёог дор дурьдсан утгаар ойлгоно.
  - 2.1.1 “Гадаад валютын хадгаламж” гэж банкнаас чөлөөтэй хөрвөх гадаад валютаар Монголбанканд байршуулах хадгаламжийг;
  - 2.1.2 “Цахим арилжааны систем” гэж дотоодын банк хоорондын арилжааг цахим системээр хийхэд зориулагдсан арилжааны системүүдийн ерөнхий нэршлийг;
  - 2.1.3 “Баталгаажсан хаяг” гэж Блүмберг системээр дамжуулан хадгаламжийн хэлцэл хийх эрх бүхий банкны ажилтны Монголбанкны мэдээллийн санд бүртгэгдсэн Блүмберг системийн ID хаягийг;
  - 2.1.4 “Зөвшөөрөгдсөн цахим шуудангийн хаяг” гэж хадгаламжийн хэлцэл хийх эрх бүхий банкны ажилтны Монголбанкны мэдээллийн санд бүртгэгдсэн цахим шуудангийн хаягийг;
  - 2.1.5 “Хадгаламжийн хэлцэл” гэж энэ журмын нэгдүгээр хавсралтын дагуу хадгаламж байршуулах захиалгыг ирүүлж, хадгаламжийн хүү, хэмжээ, хугацаа, нөхцлийг хоёр тал харилцан тохиролцож гарын үсэг, тамга тэмдгээр баталгаажсан хэлцлийг, эсхүл Блүмберг системд цахимаар баталгаажуулсан хэлцлийг.

*/Энэ заалтад Монголбанкны Ерөнхийлөгчийн 2024 оны 10 дугаар сарын 08-ны өдрийн А-234 дүгээр тушаалаар нэмэлт оруулсан./*

### **ГУРАВ. Хадгаламжийн хэлцлийн ерөнхий зарчим**

- 3.1 Банк нь хадгаламж шинээр байршуулах болон сунгах саналыг спот хугацаагаар ажлын өдрийн 14:00 цагаас өмнө энэ журмын нэгдүгээр хавсралтын дагуу

Мөнгөний захын үйл ажиллагаа хариуцсан газарт дараах байдлаар хүргүүлнэ:

- 3.1.1 Цахим арилжааны системээр;
  - 3.1.2 Блүмберг системийн өөрийн баталгаажсан хаягаар;
  - 3.1.3 Зөвшөөрөгдсөн цахим шуудангийн хаягаар;
  - 3.1.4 3.1.1-3.1.2-т заасан системд саатал гарсан тохиолдолд энэ журмын нэгдүгээр хавсралтын дагуу хэвлэмэл байдлаар 3 хувь ирүүлэх.
- 3.2 Мөнгөний захын үйл ажиллагаа хариуцсан газар нь гадаад валютын хадгаламж байршуулах саналыг судалж, хадгаламжийн хүүгийн түвшин, хэмжээг тухайн банкинд хүргүүлэх ба харилцан зөвшөөрч биелсэн хэлцлийг баталгаажуулж, өөрийн мэдээллийн санд хадгална.

*/Энэ хэсгийг Монголбанкны Ерөнхийлөгчийн 2024 оны 10 дугаар сарын 08-ны өдрийн А-234 дүгээр тушаалаар өөрчлөн найруулсан./*

- 3.3 Олон улсын төлбөр тооцооны банк (цаашид ОУТТБ гэх)-ны санал болгож буй хадгаламжийн хүүгийн түвшин нь хадгаламжийн хэлцэл байгуулах хугацаанд өөрчлөгдсөн тохиолдолд энэхүү журмын 3.2-т заасан үйл ажиллагаа дахин хийгдэнэ.
- 3.4 Банк энэ журмын 3.1.1-т зааснаас бусад хэлбэрээр хадгаламж байршуулах болон сунгах саналаа ирүүлсэн тохиолдолд Мөнгөний захын үйл ажиллагаа хариуцсан газар нь банкны саналыг цахим арилжааны системд оруулж, хадгаламжийн хэлцлийг Санхүү бүртгэл хариуцсан газарт тухайн ажлын өдрийн 16:00 цагаас өмнө хүргүүлнэ.

*/Энэ хэсгийг Монголбанкны Ерөнхийлөгчийн 2024 оны 10 дугаар сарын 08-ны өдрийн А-234 дүгээр тушаалаар өөрчлөн найруулсан./*

- 3.5 Санхүү бүртгэл хариуцсан газар нь хадгаламжийн хэлцлийн дагуу холбогдох бүх гүйлгээг тухайн банкны Монголбанканд дахь харилцах дансаар дамжуулан хийнэ.
- 3.6 Банк нь хадгаламж байршуулах өдөр тухайн валютын мөнгөн дүнг Монголбанканд дахь тус банкны холбогдох дансанд ажлын өдрийн 16:00 цагаас өмнө шилжүүлнэ.

### **ДӨРӨВ. Монголбанкны эрх, үүрэг**

- 4.1 Монголбанк дараахь эрх эдлэнэ.
- 4.1.1 Хадгаламжийн хэлцлийн шийдвэр гаргахад шаардагдах мэдээ, мэдээллийг банкнаас гаргуулан авах;
  - 4.1.2 Тухайн банкны хадгаламж байршуулах саналаас бүрэн буюу хэсэгчлэн биелүүлэхээс татгалзах, татгалзсан шалтгаанаа тайлбарлахгүй байх;
- 4.2 Монголбанк дараах үүрэг хүлээнэ:
- 4.2.1 Хадгаламжийн хэлцлийн үйл ажиллагааг хариуцах, орлон ажиллах ажилтны албан тушаал, Блүмберг ID болон цахим шуудангийн хаягийг банкуудад цахим шуудангаар хүргүүлэх;
  - 4.2.2 Хадгаламжийн хэлцлийн төлбөр тооцоог саадгүй гүйцэтгэх;
  - 4.2.3 Банкуудын хадгаламжтай холбоотой мэдээ, мэдээллийн нууцлалыг хадгалах.

### **ТАВ. Банкны эрх, үүрэг**

- 5.1 Банк дараахь эрх эдлэнэ:
- 5.1.1 Хадгаламж шинээр байршуулах болон сунгах саналыг Мөнгөний захын үйл ажиллагаа хариуцсан газарт ирүүлэх.
- 5.2 Банк дараахь үүрэг хүлээнэ:
- 5.2.1 Монголбанкнаас шийдвэр гаргахад шаардагдах мэдээ, мэдээллийг тухай бүр үнэн, зөв ирүүлэх;
  - 5.2.2 Хадгаламжийн хэлцэл хийх эрх бүхий ажилтны нэр, Блүмбергийн баталгаажсан ID хаяг, зөвшөөрөгдсөн цахим шуудангийн хаяг, хадгаламжийн хэлцлийг баталгаажуулах гарын үсгийн баталгааг бичгээр Мөнгөний захын үйл ажиллагаа хариуцсан газарт хүргүүлэх ба өөрчлөгдсөн нөхцөлд Мөнгөний захын үйл ажиллагаа хариуцсан газарт ажлын нэг өдрийн дотор дараагийн хадгаламжийн хэлцэл хийгдэхээс өмнө бичгээр мэдэгдэх;
  - 5.2.3 Ирүүлсэн хадгаламж байршуулах саналыг буцаах буюу цуцлахгүй байх;
  - 5.2.4 Хадгаламжийн эх үүсвэрийг байршуулах, хэлцлийн төлбөр тооцоог саадгүй гүйцэтгэх;
  - 5.2.5 Хадгаламжийн хэлцлийн талаарх мэдээллийн нууцлалыг хадгална.

### **ЗУРГАА. Хариуцлага**

- 6.1 Банк нь валютын эх үүсвэрийг хожимдуулсан тохиолдолд хадгаламжийн хэлцлийн мөнгөн дүнд харгалзах хугацааны ОУТТБ-ны хүүтэй тэнцэх хүүгийн торгууль ногдуулна.

*/Энэ хэсгийг Монголбанкны Ерөнхийлөгчийн 2024 оны 10 дугаар сарын 08-ны өдрийн А-234 дүгээр тушаалаар өөрчлөн найруулсан./*

- 6.2 Энэ журмын 4.2.3, 5.2.5 дахь заалтуудыг зөрчиж, хадгаламжийн хэлцлийн талаарх мэдээллийг бусдад тараасан ажилтанд хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.
- 6.3 Энэ журмын 5.2.2-т заасан заалтыг зөрчсөнөөс үүдэн гарах аливаа хохирлыг Монголбанк хариуцахгүй болно.

“Дотоодын банкнаас Монголбанканд гадаад валютын хадгаламж байршуулах журам”-ын нэгдүгээр хавсралт

## ХАДГАЛАМЖ БАЙРШУУЛАХ ХЭЛЦЭЛ

20... оны ... сарын ... өдөр  
хот

Улаанбаатар

### Нэг. Хадгаламжийн нөхцөл

Хадгаламж байршуулах банк: .....

Валютын нэгж: .....

Дүн: ...../Үсгээр/

Хүүгийн хувь /жилийн/: .....хувь

Хадгаламжийн хугацаа: .....хоног

### Хоёр. Бусад

1. .... банк нь 20... оны ... сарын ... өдөр ...../мөнгөн дүн/ /валютын нэгж/....-ийг Монголбанканд дахь тус банкны ..... тоот дансанд шилжүүлнэ.
2. Монголбанк нь 20... оны ... сарын ... өдөр ...../мөнгөн дүн/ /валютын нэгж/....-ийг түүний ... хоногийн хүүгийн хамт ..... банкны Монголбанканд дахь ..... тоот дансанд буцаан төлнө.

### Хэлцэл хийсэн:

МОНГОЛБАНКИЙГ ТӨЛӨӨЛЖ:

.....БАНКИЙГ ТӨЛӨӨЛЖ:

ТЭМДЭГ:

ТЭМДЭГ:

ЦАХИМ ШУУДАНГИЙН ХАЯГ: